



САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ Ж.ОРХОНБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ/


ХЯНАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАГНАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Тэмдэг



/Ц.АРИУНСАНАА/

/Ж.ОРХОНБАЯР/

(огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
8 дугаар хавсралт

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ Ж.ОРХОНБАЯРЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Xүрэх тувшин	Хүрсэн тувшин /биелэлт/ эхэлсэн, дууссан огноо, биелэлтийн хувь
			Эхний хагас жил	
1	2	3	4	5

Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих:

ЗОРИЛТ 5.2. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах

5.2.1	Улсын төсөв, зээл, тусламжаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах	ШҮ1: Цахим Тендерийн тоо; ШҮ2: Хэрэгжилтийн хувь	2024 оны тендерийн тоо-8 дээш, Хэрэгжилтийн хувь-100 хувь.	2024 онд тус яаманд зохион байгуулагдах 16 төсөл, арга хэмжээ, үүнээс 13 төсөл, арга хэмжээний тендерийг цахимаар зарласан. Үүнд: Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 56 дугаар тушаалаар батлагдсан “Солонго 1,2” төслийн монголын талын хөрөнгөөр хэрэгжүүлэх гадна инженерийн шугам сүлжээний 3 ажил, Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 88 дугаар ташаалаар “Залуус 1, 2 дугаар хорооллын инженерийн шугам сүлжээ, цахилгаан хангамж /Дархан-Уул, Дархан сум/” төсөл, арга хэмжээний задаргаа батлагдаж 7 төсөл, арга хэмжээ, нийт 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсанаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар 22 төсөл, арга хэмжээний тендерийг цахимаар зарласан. 4 төсөл, арга хэмжээний хувьд зураг төсөв, техникийн тодорхойлолт боловсруулах шатанд байна. Тус яаманд зохион байгуулсан тендер шалгаруулалтын зохион байгуулах хүрээнд дараах ажлуудыг хийж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:	100
-------	--	---	--	---	-----

				<p>1. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороо байгуулах ажлын хүрээнд тус яаманд буртгэлтэй, худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай албан хаагчид болон Төрийн бус байгууллагын төлөөлүүдээс бүрдсэн 17 үнэлгээний хороо байгуулах тушаал боловсруулан батлуулж, уг тушаалуудын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-д эрх үүсгэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд боловсруулж, төсөл, арга хэмжээ тус бүрээр хянан баталгаажуулан нийтлэсэн.</p> <p>3. Яам болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулагдах тендер шалгаруулалтын ажлуудын зураг төсөв, техникийн тодорхойлолтыг бэлэн болгож, тендер зарлах нөхцлийг бүрдүүлэх хүрээнд 13 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хугацаатай албан бичиг хүргүүлсний үр дүнд холбогдох зураг төсвүүдийг ирүүлж, тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж ажилласан.</p> <p>4. Мөн тус яаманд зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарт тухай бүр мэргэжил аргазүйн зөвлөмж өгч, цахим системээр ирүүлсэн тендерийн урилга бүрийг захиалчийн эрхээр баталгаажуулан ажилласан.</p>	
5.2.7	Арга хэмжээ 5.2.7: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах	ШҮ1:Гэрээний хэрэгжилт-46,9 хувь ШҮ2:ТЭЗҮ, зураг төслийн ажлын гэрээний хэрэгжилт-100 хувь	2024 онд хэрэгжүүлэх нийт 1,145,3 тэрбум төгрөгийн 405,3 тэрбум төгрөгийн 405,3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 179 төсөл, арга хэмжээнээс 2024 онд дуусах 84 төсөл, арга хэмжээнээс 2024 оны хагас жилийн байдлаар нийт 35 төсөл, арга хэмжээ улсын комисст хүлээлгэн өгсөн.	2024 онд хэрэгжүүлэх нийт 1,145,3 тэрбум төгрөгийн 405,3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 179 төсөл, арга хэмжээнээс 2024 онд дуусах 84 төсөл, арга хэмжээнээс 2024 оны хагас жилийн байдлаар нийт 35 төсөл, арга хэмжээ улсын комисст хүлээлгэн өгсөн.	90

		<p>дуусах 84 төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, бүрэн дуусгасан байна.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төслийн ажлуудаас 2023 оны жилийн эцэст барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн 25 төсөл, арга хэмжээнээс 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5 төсөл, арга хэмжээ бүрэн дууссан ба Засгийн газрын 2023 оны 456 дугаар тогтоолын дагуу уг төсөл, арга хэмжээнүүдийг 2024 оны 10 сарын 30-ны өдөр хүртэл хэрэгжүүлж дуусахаар заасан ба уг хугацаанд багтаан дуусахаар гэрээний сунгалтуудыг баталгаажуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хөрөнгө оруулалтын ажлуудын уялдааг хангаж, эрчимжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/38 дугаар тушаал боловсруулж батлуулсан ба Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газрын дарга Ц.Ариунсанаа нийт 19 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг ахалж, нэгдсэн хуралдаан зохион байгуулсан ба удаашралтай ажлуудын шалтгаан нөхцлийг судлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж гаргах, шаардлагатай ажлуудыг газар дээр нь дэд ажлын хэсгийн хүрээнд үзэж, санал дүгнэлт гаргах, санхүүжилт нь 2024-2026 онд шилжин хэрэгжиж болон Засгийн газрын тогтоолоор хугацаа зааж, барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, ажлын хуваарийн дагуу хэвийн үргэлжилж байгаа ажлуудын гэрээний хугацааг сунгах, гүйцэтгэгч компанийн хариушлагагүй байдлаас хамаарч ажил удааширч, зогссон төслүүдийг холбогдох хуулийн дагуу дүгнэж, гэрээ цүшлэх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 5 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, цүшлэх ажил хийгдэж дуусах шатанд байгаа ба уг компаниудад шат шатны хариушлага тооцох хүрээнд Сангийн яамны эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэгт санал хүргүүлэхээр бэлтгэл хангаж байна. Мөн дээр дурдсан ажлуудыг төсөл, арга хэмжээ</p>	
--	--	--	--

			<p>яамны холбогдох албан хаагчдад хариуцуулж, биелэлтийг нэгтгэн ажиллаж байна.</p> <p>Гэрээт ажлуудын хүрээнд өмчлөлийн асуудал шийдвэрлэх шаардлагатай “Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны шинэчлэл /Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаар хороо/” төслийн хүрээнд бий болох орон сууцны барилгын өмчлөл, ашиглалтын асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газрын дарга Ц.Ариунсанаа ахалж ажилласан ба уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны холбогдох албан хаагчид, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, “Нийслэлийн өмчийн харилцааны газар” ОНӨААТҮГ, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК, Налайх дүүргийн Засаг дарга болон ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудын бүрэлдэхүүнтэйгээр газар дээр нь хуралдаж холбогдох шийдвэр, санал дүгнэлтийг гаргаж, удирдлагуудад танилцуулан баталгаажуулж, Сангийн яаманд хүргүүлээд байна.</p> <p>Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа Залуус 1,2 хороолол төслийн инженерийн шугам сүлжээний ажлуудыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, мэргэжилтнүүд, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудын хамт газар дээр нь очиж шийдвэрлэн, холбогдох дүгнэлтийг гаргаснаар дараагийн шатны ажлууд эрчимжих боломж бүрдсэн зэргээр гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p>	
--	--	--	---	--

Зорилт 5.5: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах.

5.5.4	<p>Арга хэмжээ 5.5.4: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн гүйцэтгэлийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулах</p>	<p>ШҮ1: Шилэн данс болон яамны цахим хуудсанд хуулийн хугацаанд үнэн зөв нийтэлсэн мэдээллийн тоо -26</p>	<p>Хуулийн хугацаанд Шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд 13 мэдээллийг бүрэн байршуулсан байна.</p>	<p>Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайланда хийсэн хяналт шалгалтын дүн, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг нийт 25 мэдээллээс эхний хагас жилийн байдлаар 13 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.</p>	100
-------	---	--	--	---	-----

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур γзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт
				Эхний хагас жил	
	1	2	3	4	
1	Монгол бичгийн бичгийн чадвараа сайжруулж, албан хэрэг хөтөлбөрт хэрэглэж хөөшинэ.	Суралцсан цаг	20 цаг	10 цаг	"Монгол бичгийн дүрэм"-ийн талаар Я.Надмид багшийн онлайн хичээлийг бие даан суралцсан. Мөн "Монол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь" цахим хичээлийг бие даан судалсан. Нийт судалсан цаг 10 цаг
2	Санхүү, эдийн засгийн чиглэлээр Магистрын зэрэгт суралцана.	Суралцсан кредит цаг	7	7	Улаанбаатар эрдэм оюу дээд сургуульд магистрийн ангид элсэн орж, суралцаж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт суралцах ёстой цагаас 7 кредит хичээл судалж, эхний семиистрийн хичээл дуусгасан.
3	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлнэ	Суралцсан цаг	20 цаг	10 цаг	Улаанбаатар эрдэм оюу дээд сургуулийн эдийн засгийн

				магистрийн ангид англи хэлний 5 цагийн хичээл судалсан. Мөн цахим орчинд 5 цагийн хичээлийг бие даан судалсан.
--	--	--	--	---

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ж.ОРХОНБАЯР

